

**ДОРНОД АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

**ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт
/ гэрээний нэр:** Сургуулийн барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум 12-р сургууль/

**Тендер шалгаруулалт
/ гэрээний дугаар:** УТХ- XII.5.1.4.32/2020

Дорнод аймаг, Хэрлэн сум

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020-02-19

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Сургуулийн барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум 12-р сургууль/” гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Цахим тендерийн хураамж 50,000 төгрөг.

Үнийн саналыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ашиглан **2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минутад нээнэ.

Давуу эрх тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг,

Аймгийн ЗДТГ-ын 3 дугаар байрны 2 дугаар давхар.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар

Утас: 7058-3058

Факс: 7058-4058

Цахим шуудан: info@umch.dd.gov.mn

Цахим хуудас: www.umch.dd.gov.mn, www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дунд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дунг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дунг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дунг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт																
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 52,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум 12-р сургууль/”-ын ажил гүйцэтгэх тендертээ үнийн саналын хамт дараах мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын талаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалттын газар /эсвэл түүнтэй адилтгах холбогдох мэргэжлийн байгууллага/-ын тодорхойлолт /2020 оны байдлаар/, - 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын гэрээний мэдээлэл, 																
	<table border="1"> <thead> <tr> <th>Д.Д</th><th>Гэрээний нэр</th><th>Гэрээний дүн</th><th>Захиалагч, холбоо барих хаяг</th><th>Эхэлсэн огноо</th><th>Дууссан огно</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td><td>.....</td><td>....</td><td>....</td><td>....</td><td>....</td></tr> </tbody> </table>					Д.Д	Гэрээний нэр	Гэрээний дүн	Захиалагч, холбоо барих хаяг	Эхэлсэн огноо	Дууссан огно	1.
Д.Д	Гэрээний нэр	Гэрээний дүн	Захиалагч, холбоо барих хаяг	Эхэлсэн огноо	Дууссан огно												
1.												
	<ul style="list-style-type: none"> - Тендерийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл, - Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрсөн мэдэгдэл, - Тендерт ирүүлсэн мэдээллийн талаар холбогдох байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл, - Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна. Үүнийг тендерт шалгарсан тохиолдолд зээл олгох тухай банкны тодорхойлолт, эсвэл дансны үлдэгдлээр тодорхойлно. - Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй өртөгтэй ижил төстэй ажил 2018, 2019 оны аль нэгэнд гүйцэтгэсэн байх шаардлагатай бөгөөд энэхүү ажлын гэрээ, актын хуулбарыг ирүүлнэ. - Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны борлуулалттын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх шаардлагатай. - Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу барилгын засварын ажилд ашиглах Монгол улсын гарал үүсэлтэй бараа, материалын жагсаалт, хэмжээг хүснэгтийн дагуу гаргаж ирүүлэх. 																
	<table border="1"> <thead> <tr> <th>Д.Д</th><th>Бараа, материалын нэр, төрөл</th><th>Хэмжих нэгж</th><th>Тоо хэмжээ</th><th>Нэгжийн үнэ</th><th>Нийт үнэ</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td><td>.....</td><td>....</td><td>....</td><td>....</td><td>....</td></tr> </tbody> </table>					Д.Д	Бараа, материалын нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	1.
Д.Д	Бараа, материалын нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ												
1.												
	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барилга, хот байгуулалттын яамны “БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүжлээ, тэдгээрийнт тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүжлээний угсралт” - Барилга, хот байгуулалттын яамны “БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтүүн ажил” 																

	<p>Ажил гүйцэтгэхэд дараах инженер техникийн ажилтнууд шаардлагатай. Нэг ажлын байранд нэг хүн санал болгоно. /НД дэвтрийн хуулбар, сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын тооцооны хуудас НД8 маягтаар, ажилд томилсон тушаал, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, дипломын хуулбарыг хавсаргана, гэрээгээр ажиллах бол гэрээний хуулбар/.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Д.д</th><th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Ажлын туршлага /жилээс багагүй/</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Ерөнхий инженер</td><td>1</td><td>3</td></tr> <tr> <td>2</td><td>Сантехникийн инженер</td><td>1</td><td>2</td></tr> <tr> <td>3</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан /үндсэн ажилтан байна/</td><td>1</td><td>2</td></tr> </tbody> </table> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>Д.Д</th><th>Машин механиз, тоног төхөөрөмжийн төрөл</th><th>Тоо, ширхэг</th><th>Хүчин чадал /багагүй/</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td><td>Ачааны авто машин</td><td>1</td><td>3 тн</td></tr> </tbody> </table> <p>Бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган ирүүлнэ. Санал болгож буй машин, механизмийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, түрээслэх бол түрээсийн гэрээг тендерийн хамт ирүүлэх шаардлагатай.</p>	Д.д	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага /жилээс багагүй/	1	Ерөнхий инженер	1	3	2	Сантехникийн инженер	1	2	3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан /үндсэн ажилтан байна/	1	2	Д.Д	Машин механиз, тоног төхөөрөмжийн төрөл	Тоо, ширхэг	Хүчин чадал /багагүй/	1.	Ачааны авто машин	1	3 тн
Д.д	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага /жилээс багагүй/																						
1	Ерөнхий инженер	1	3																						
2	Сантехникийн инженер	1	2																						
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан /үндсэн ажилтан байна/	1	2																						
Д.Д	Машин механиз, тоног төхөөрөмжийн төрөл	Тоо, ширхэг	Хүчин чадал /багагүй/																						
1.	Ачааны авто машин	1	3 тн																						
ТОӨЗ 1.1	<p>Тендер бэлтгэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> - Зураг төсөв, ажлын тоо хэмжээтэй уялдуулан тооцсон төсөв, ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг гаргаж, баталсан байна. - Магадлашгүй ажлын зардал, захиалагчийн хяналтын зардлыг төсөв зохиох зааврын дагуу, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардлыг хяналтын төсөвт тусгасан дүнгээр, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцон төсөвт өргтийн нэгдсэн товчоонд тусгасан байх бөгөөд үнийн саналдаа багтсан байна. - Тендерийн баримт бичигт шаардсан мэдээллийг ирүүлээгүй нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно. 																								
ТОӨЗ 1.1	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 14 зүйлд зааснаар Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</p> <p>Үүний дагуу тендертээ:</p> <ul style="list-style-type: none"> - Харьяа нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, - Харилцагч банкуудаас хугацаа хэтэрсэн өр, төлбөртэй эсэх тухай тодорхойлолтыг гарган ирүүлнэ. <p>Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p>																								
ТОӨЗ 2.1	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар, 210 тоот. Орон нутгийн өмчийн газар Утас: 7058-3058 Факс: 7058-4058 Цахим шуудан: info@umch.dd.gov.mn Цахим хуудас: www.umch.dd.gov.mn, www.tender.gov.mn Ш/Х-250 Тендер шалгаруулалттай холбоотой ажлын 3 хоногоос өмнө гаргасан тодруулгыг хүлээн авч хариу өгнө.</p>																								

ТӨӨЗ 2.1	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерт дараах нэр, ялгах дугаарыг тэмдэглэнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тендер шалгаруулалтын нэр: “Сургуулийн барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум 12-р сургууль/-ын тендер - Тендер шалгаруулалтын дугаар: УТХ-XII.5.1.4.32/2020 - Оролцогчийн нэр, хаяг, холбоо барих хаяг.
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах: <p>Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлж буй тендер болон оролцож байгаа тендерийн нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ. Уншигдах боломжгүй материалыг үнэлгээнд харгалзан үзэхгүй, татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар: <p>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар, 210 тоот Орон нутгийн өмчийн газрын хурлын өрөө</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.3	Долдугаар бүлгийн маягуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох /хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу/ дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар - Тусгай зөвшөөрлийн баталгаажуулсан хуулбар - Шүүхийн байгууллагын тодорхойлолт - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт - Харилцагч банкуудаас гаргасан хугацаа хэтэсрэн өр, төлбөргүй тухай тодорхойлолт <p>Бусад нууцлах шаардлагатай баримт бичиг, материалыг үндэслэлийн хамт тусад нь бэлтгэсэн байна.</p>
ТӨӨЗ 2.3	“Баталгаажуулсан” гэдэгт сүүлийн 6 сарын дотор нотариатаар баталгаажуулсныг ойлгоно. Тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байх шаардлагатай.
ТӨӨЗ 2.3	Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар баталсан журмын давуу эрх тооцно. Тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлт, нотлох баримт, холбогдох мэдээллийг тендерийн хамт ирүүлнэ.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, улсын стандартыг мөрдөх ба БНБД 12-01-09, БНБД 12-03-04, БНБД 12-04-06, БД12-101-05, БД12-106-14-ийг мөрдлөг болгоно. БНБД12-01-09-ын хавсралтын дагуу:

- а.Ажил гүйцэтгэх шугаман сүлжээ график
- б.Барилга үйлдвэрлэлийн технологийн картыг гаргах

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрлэлийн материалыг сонгон авбал "Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ", лабораторын шинжилгээний дүн падаан хавсаргана. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүн барилгын хувийн хэрэгт хавсаргана. Цутгалтын ажлаас сорилын шоо цохих журмын дагуу авч лабораторын дүгнэлт гаргуйж байна.

Ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж өгнө.

Хэрвээ ажлын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэсэн ил далд ажлыг акт, схем зураг, фото зургаар баталгаажуулж тухайн барилгын захиалагчийн төлөөлөгч, барилгын улсын байцаагч, ашиглагчтай зөвшилцсэн байна.

Дээрх техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоо хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

Барилгын ажлыг улсын комисст хүлээлгэн өгөхдөө гүйцэтгэлийн зураг гаргаж өгнө.

Тав. ЗУРАГ

/Төсвийг www.tender.gov.mn цахим хуудаст хавсаргсан болно./

Зургаа. **ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

/Үнэлэгдсэн үе шатны хуваарь, төсөв бэлтгэхдээ ажлын тоо хэмжээг хяналтын төсвөөс авч тусгана уу. Төсвийг www.tender.gov.mn цахим хуудаст хавсаргсан болно./

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ДОРНОД АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Ч.НЭРГҮЙ ТАНАА**

1. Бид, [тэндерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тэндериин үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Төслийн менежерийн шийдвэр</p> <p>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>4. Аюулгүй байдал</p> <p>5. Зааварчилгаа</p> <p>6. Маргааныг шийдвэрлэх</p> <p>7. Ажлын хөтөлбөр</p> <p>8. Зөрчил, гологдол илрүүлэх</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> <p>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> |
|--|---|

9. Зөрчил, гологдол арилгах	9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежертууд хүргүүлнэ.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- | | |
|--|---|
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага | <p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p> |
| 18. Гэрээг цуцлах | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none">(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> |
| 19. Гэрээг цуцалсан | <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ</p> |

**үед хийх
төлбөр**

мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: [Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]
ГЕН 2.1	Ажил нь [товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь [байршил]-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр [огноо] Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [огноо] ⁴
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [тоо] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа [тоо] хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [хувь] байна. ⁵ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [огноо]-ны дотор гаргаж өгнө.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

	Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь]-иар тооцно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____
хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай,
_____ суурь, _____ хана,
_____ хучилттай, _____ давхар _____ барилга
угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____
инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/,
_____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар
сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;

- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]